

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлөөс 2024 оны (хамрах хугацаа 01/02-12/10) дүнгээр гүйцэтгэсэн ажлын товч тайланг танилцуулж байна.

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын талаар:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд жилийн дүнгээр салбар зөвлөлөөс төрийн захиргааны удирдах 1, төрийн тусгай албаны удирдах 8, төрийн захиргааны гүйцэтгэх 7, төрийн тусгай албаны гүйцэтгэх 37 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлууллаа.

Хүснэгт-1

№	Албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2024.01.24 №01	1	3	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн дарга- 1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
2	2024.03.13 №02	-	4	Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн-3.
3	2024.04.29 №04			Санхүү, хангалт үйлчилгээний газрын мэргэжилтэн-3;
4	2024.06.24 №05	-	16	Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн-3; Дорноговь аймаг дахь газар ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-2; Өмнөд бүс дэх газар ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-2; Баруун бүс дэх газар ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-2; Хойд бүс дэх газар мэргэжилтэн-1; Зүүн бүс дэх газар ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-2; Баян-Өлгий аймаг дахь хэлтэс мэргэжилтэн-1.
5	2024.07.01 №06	7	-	Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга-1; Мэдээллийн технологийн хэлтсийн дарга-1; Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн дарга-1; Хилийн боомт, орон нутаг дахь газрын дарга-3; Хилийн боомт, орон нутаг дахь хэлтсийн дарга-1
6	2024.10.02 №07	-	12	Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн-2; Хилийн боомт, орон нутаг дахь газрын ахлах мэргэжилтэн-1; Хилийн боомт, орон нутаг дахь газрын хяналтын улсын байцаагч-8; Хилийн боомт, орон нутаг дахь газрын мэргэжилтэн-1.
7	2024.10.15 №08	1	-	Хилийн боомт, орон нутаг дахь хэлтсийн дарга-1
8	2024.11.05 №09	-	2	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс мэргэжилтэн-2

9	2024.11.29 №10	-	7	Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн-4; Хилийн боомт, орон нутаг дахь газрын мэргэжилтэн-1; Хилийн боомт, орон нутаг дахь газрын хяналтын улсын байцаагч-2;
ДҮН		9	44	

Төрийн албаны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасныг хэрэгжүүлж, байгууллагын [immigration.gov.mn](http://immigration.gov.mn) цахим хуудсанд “Сонгон шалгаруулалтын зар” цэс, зарын дагуу төрийн жинхэнэ албан хаагчдаас баримт бичиг хүлээн авах [shalgalt@immigration.gov.mn](mailto:shalgalt@immigration.gov.mn) цахим хаягийг ажиллуулж, Төрийн албаны зөвлөлийн цахим системээс шууд шилжих боломжийг бүрдүүлсэн.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд өссөн дүнгээр салбар зөвлөлөөс 8 удаа удирдах 9, гүйцэтгэх 37 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5-аас доошгүй хоног байгууллагын [www.immigration.gov.mn](http://www.immigration.gov.mn) цахим хуудсаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн.

Дээрх 9 удаагийн зарын дагуу 8 иргэн [shalgalt@immigration.gov.mn](mailto:shalgalt@immigration.gov.mn) цахим хаягаар Захиргаа, удирдлагын газарт нийслэлийн Газар, зохион байгуулалтын албанаас төрийн захиргааны дэс түшмэлийн 1, Дорноговь аймаг дахь газарт төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, Баруун бүс дэх газарт Увс аймаг дахь хэлтсээс төрийн жинхэнэ албан хаагч 1, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, нийт 4 мэргэжилтний албан тушаалд хүсэлт ирүүлсэн. Үүнээс тухайн албан тушаалын тодорхойлолт болон шаардлага хангасан 2 төрийн жинхэнэ албан хаагчийг Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтэн, Баруун бүс дэх газарт мэргэжилтнээр тус тус шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд салбар зөвлөлийн 01, 06, 11, 16, 26, 28, 37 дугаар тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комисс байгуулж, удирдах 9, гүйцэтгэх 23 албан тушаалын сул орон тоо нөхөх 7 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа. Тусгай шалгалтад тэнцсэн иргэдийн 19 буюу 59.3 хувь нь 2021-2024 оны төрийн албаны ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй иргэд, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэн 3 буюу 9.3 хувь, 10 буюу 31.2 хувь төрийн жинхэнэ албан хаагч, нээлттэй зарлуулсан 32 сул орон тооноос 5 буюу 15.6 хувь нь нөхөгдөөгүй.

## Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Сул орон тоог		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	Нөхсөн	Нөхөөгүй	
1	2024.01.05	-	3	3	-	-
2	2024.02.14	1	2	3	-	-

3	2024.04.10	-	4	3	1	Бүртгүүлээгүй
4	2024.07.30	7	-	7	-	-
5	2024.10.30	-	12	8	4	Бүртгүүлээгүй-2, босго оноонд хүрээгүй-2
6	2024.11.15	1	-	1	-	
7	2024.11.29	-	2	2	-	
ДҮН		9	23	27	5	

Хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаал, зарим төрийн үйлчилгээний албан тушаалууд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан мэдээллийн технологийн болон санхүүгийн чиг үүрэг хэрэгжүүлдэг 16 албан хаагчийг тусгай шалгалтад хамруулах захиалгыг салбар зөвлөлийн 04 дүгээр сарын 29-ний өдрийн 04, 06 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн бөгөөд төрийн тусгай албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 06 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр хуралдаанаар хэлэлцэж, 283, 284 дүгээр тогтоолоор зөвшөөрөл олгосон.

Дээрх захиалгын дагуу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөл 08 дугаар сарын 23, 26-ны өдрүүдэд зохион байгуулж, 16 албан хаагчаас 15 буюу 93.7 хувь нь тусгай шалгалтад тэнцэн 09 дүгээр сарын 06-ны өдрийн 341, 342, 343 дугаар тогтоолоор нэр дэвшүүлснийг хууль тогтоомжийн хүрээнд 09 дүгээр сарын 16-ны өдрөөс тухайн албан тушаалд нь жинхэлж томилон, цалин, нэмэгдэл хөлсийг олгож байна.

Тухайн албан тушаалын буюу тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн [hh-admin.csc.gov.mn](http://hh-admin.csc.gov.mn) цахим системээр зохион байгуулж, сонгон шалгаруулалтын захиалга, зар оруулах, бүртгэх, шалгалт авах, дүнг мэдээлэх бүх үйл явц цахимаар явагдаж хэвшсэн.

Гурав. Бусад үйл ажиллагааны талаар:

Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд өмнө төрийн захиргааны ангилал, зэрэглэлд хамаарч байсан 220, төрийн үйлчилгээний ангиллаас төрийн тусгайд 26 албан тушаал шилжсэн, 6 орон тоо нэмэгдсэнтэй холбогдуулан удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар байгуулж ажиллуулсан.

Уг ажлын хэсэгт төв байгууллагын газар, хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, Захиргаа, удирдлагын газрын хүний нөөцийн мэргэжилтнүүд 252 төрийн тусгай албан тушаалд хамаарах удирдах 12, гүйцэтгэх 64 албан тушаалын тодорхойлолтын боловсруулалтыг хийж, Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газраар хянуулан өгсөн зөвлөмж, чиглэлийг тусгаж, Төрийн албаны зөвлөлийн 06 дугаар сарын 19-ний өдрийн 24 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн 283, 284 дүгээр тогтоолоор нийт 76 төрийн тусгай албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл авлаа.

Төрийн албаны тухай хуулийн 36.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 82 дугаар зарлигаар шинэчлэн баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 07 дугаар сарын 01-ний өдрийн 17

дугаар, 11 дүгээр сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолоор нийт 27 албан хаагчийг тангараг өргүүлээ.

Төрийн албаны өдрийг тохиолдуулан 07 дугаар сарын 03-ны өдөр төв байгууллагын Хүндэтгэлийн танхимд, Баруун бүс дэх газарт албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн, төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон төвийн нэгжийн 3, хилийн боомт, орон нутаг дахь газрын 3, нийт 6 албан хаагч, “Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр”-ийг тохиолдуулан 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан арга хэмжээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр төрийн үйлчилгээний албан тушаалаас төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжиж, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан тусгай шалгалтад тэнцсэн 15, салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн 6, нийт төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 21 албан хаагчийг оролцуулж, төв байгууллагад нэгдсэн байдлаар ёслолын ажиллагааг зохион байгуулсан.

Тангаргийн ёслол Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 304 дүгээр тогтоолоор баталж, 09 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн “Тангаргийн хуудас”-ны загварын дагуу хэвлүүлсэн хуудсаар анх удаа тангараг өргүүлсэн онцлог арга хэмжээ боллоо.

Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөл болон холбогдох дээд шатны байгууллагад дараах мэдээ, судалгааг хүргүүлсэн. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны “Хүний нөөцийн аудитын сэдэв, төлөвлөгөө батлах тухай” 156 дугаар тогтоол, 2024 оны “Хүний нөөцийн аудитын багийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” 136 дугаар тушаалын дагуу байгууллагын даргын 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Хүний нөөцийн аудитын багтай хамтран ажиллах ажлын хэсэг байгуулах тухай” А/382 дугаар тушаалаар “Төрийн байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн” хүний нөөцийн аудит хийх Төрийн албаны зөвлөлийн аудитын багтай хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад, аудитын багтай хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх, ажиллах орчин, нөхцөлөөр хангаж, ажил үүргийн зохион байгуулалт хийхийг ажлын хэсгийн дарга, Захиргаа, удирдлагын газрын даргад тус тус үүрэг болгосон.

Хүний нөөцийн аудитыг Төрийн албаны зөвлөлийн ажлын хэсгээс ирүүлсэн удирдамж, төлөвлөгөө, хуваарийн дагуу 09 дүгээр сарын 23-30-ны өдрүүдэд хийж, “Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн”-г тодорхойлох хүний нөөцийн аудитын тайланг нэгтгэн 10 дугаар сарын 08-ны өдрийн 01/2000 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлээ.

Төрийн албаны зөвлөлөөс баталсан хуваарьт хугацаанд буюу 10 дугаар сарын 04-ний өдөр хилийн боомт, орон нутаг дахь нэгжид ажиллаж байгаа 1 албан хаагчийг харьяалах нутаг дэвсгэрийн салбар зөвлөлд, Гадаадын иргэн, харьяатын

газрын дэргэдэх салбар зөвлөлд Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, зарим орон нутгийн 10 албан хаагч, нийт 12-оос 11 буюу 91.6 хувийг хамруулсан.

Үндэсний аудитын газраас төрийн байгууллагуудын хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит хийхтэй холбогдуулан 2012-2023 оны хоорондох бүтэц, орон тоо, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн, үйлчилгээний мэдээлэл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгийг 2023.12.31-ний өдрийн байдлаар ажиллаж байсан албан хаагч бүрээр тоон мэдээллийг нэгтгэн цахимаар илгээсэн.

Тайлант хугацаанд төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

1.2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар албан хаагчид нь төрийн тусгай албан хаагчийн ангилалд багтсан. Хуулийн 41.14, 41.18-д “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтооно” гэж заасны дагуу Төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр батлуулсан.

Дээрх хууль тогтоомжийн дагуу байгууллагын бүтэц зохион байгуулалт, орон тоонд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснээр “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаал батлагдсан. Мөн байгууллагын даргын Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай А/157, Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай А/158 дугаар тушаалыг тус тус баталлаа.

Хууль тогтоомжийн хүрээнд төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн төрийн тусгай 252, төрийн үйлчилгээний 64 албан тушаалын 316 орон тооноос буюу 79.7 хувь нь төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарч, цалин хөлс, нэмэгдэл (онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны) дунджаар 64 орчим хувиар нэмэгдлээ.

2.Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл төрийн тусгай албан тушаалд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд Төрийн албаны хуулийн 57.2.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолд

заасны дагуу албан хаагчид цол олгох, хураах, хэрэглэх, мэргэшлийн зэрэг, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр боловсруулж, байгууллагын даргын А/159, А/241 дүгээр тушаалаар тус тус баталж, албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл хөлсийг дараах байдлаар шинээр болон шинэчлэн тогтоосон.

Авсан арга хэмжээ	Албан хаагчийн тоо
Албан тушаалын үндсэн цалин	201
Зэрэг дэвийн нэмэгдэл	42
Цолны нэмэгдэл	198
Мэргэшлийн зэргийн нэмэгдэл	178

3.Төрийн албаны тухай хуулийн 61.1, 61.1.1, 61.1.10, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.20-д заасны дагуу “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох журам”-ын 09 дүгээр сарын 30-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулга, харьцуулалтыг танилцуулж, байгууллагын даргын 10 дугаар сарын 01-ний өдрийн А/406 дугаар тушаалаар баталсан.

Хууль тогтоомжийн дагуу тайлант хугацаанд /2024.01.02-2024.12.01/ хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшууллыг байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/20, Б/21, 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/58, 04 дүгээр сарын 26-ны өдрийн Б/102, 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/128, Б/129, Б/130, 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/133 дугаар тушаалаар хилийн боомт, орон нутгийн нэгжид ажиллаж буй 8 хяналтын улсын байцаагчид 271.0 сая төгрөгийн урамшуулал олгосон.

4.Төрийн албаны тухай хуулийн 59.1.8, 61.1, 61.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 18.1.1, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.10, “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 3.9-д заасны дагуу санхүүгийн эх үүсвэрт нийцүүлэн байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар хоолны нөхөх төлбөрийг 34,000, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлснээр цалин, хөлсний орлого дунджаар 400,000 төгрөгөөр нэмэгдүүлээ.

5. Мөн холбогдох хууль тогтоомжийн дагуу “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам”-ыг шинээр байгууллагын даргын 06 дугаар сарын 20-ны өдрийн А/241 дүгээр тушаалаар батлуулж, шаардлага хангасан 190 албан хаагчид 10-20 хүртэл хувийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл 06 дугаар сарын 03-ны өдрөөс олгож эхэллээ.

6.Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлын үр дүнг харгалзан тайлант хугацаанд 3 удаа давхардсан тоогоор 379 албан хаагчид 443,9 сая үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.

7.Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор шинэчлэн тогтоосон “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-д 2024 оны 84 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан төвийн нэгжийн 4, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 7, нийт 11 (ахлах архив-операторч, сан хөмрөгийн эрхлэгч, архив-бичиг хэргийн эрхлэгч, бичиг хэргийн эрхлэгч, бичээч) төрийн үйлчилгээний нийтлэг зэрэглэлээс төрийн үйлчилгээний мэргэжлийн зэрэглэлд шилжүүлж албан тушаалын үндсэн цалинг нэмэгдүүлсэн.

8.Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-д заасны дагуу хилийн боомт, орон нутгийн нэгжийн 48 төрийн үйлчилгээний албан хаагчид 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үндсэн цалингийн 20 хувиар орон нутгийн нэмэгдэл олгож эхэллээ.

9.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг долоо хоногийн нэг өдөр зайнаас ажиллуулахтай холбоотой харилцааг зохицуулсан “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам”-ыг 09 дүгээр сарын 30-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, байгууллагын даргын 10 дугаар сарын 01-ний өдрийн А/407 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ  
САЛБАР ЗӨВЛӨЛ